



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/148

Чингис хот

"Эргэх холбоо" уулзалт, арга хэмжээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнийн санаачилгаар 2016 оноос эхлэн амжилттай хэрэгжиж буй "Эргэх холбоо" орон нутгийн иргэд, хөдөлмөрчид, залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжил, оролцоог дэмжих хөтөлбөрийн хүрээнд Хэрлэн суманд зохион байгуулагдсан эмэгтэйчүүдийн чуулга уулзалт, арга хэмжээнд 4400000 /дөрвөн сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

03
Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 14 өдрийн А/М/Д
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэрс	Нэгжийн үнэ	Нийт хэрэглэгдэх тоо	Нийт үнэ
1	Өдрийн хоол	18000	110	1980000
2	Оройн хоол	22000	110	2420000
		Нийт үнэ		4 400 000